



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

	Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02	БАТРАА ГҮЙЦЭТГЭЭ ЗАХИРАЛ
		Хувилбар: 1	М.Ганбаатар
		Тушаал № А/92	Баталсан огноо: 2020 он 04 сар 06 өдөр

ӨНДӨРТ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

ӨНДӨРТ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага	4
Хоёр. Уналтаас сэргийлэх	4
Гурав. Дээрээс эд зүйл унах.....	6

Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 1.1. Газрын төвшин, тавцангаас дээш 1.3 метрийн өдөрт гарах, газрын төвшнөөс доош 1.3 метрээс илүү гүнд орох болон түүний ирмэг амсрын ойролцоо ажил үүрэг гүйцэтгэх ажилтан нь тусгай хөтөлбөрөөр суралцаж, компанийн ХАБЭА-н ажилтан болон инженер техникийн ажилтнаас өндөрт ажиллах эрх авсан байна.
- 1.2. Ажилтан эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдаж өндрийн ажил гүйцэтгэх шалгуурыг хангасан байна.
- 1.3. Өндрийн ажил гүйцэтгэх ажилтан нь өндрийн ажлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг шууд удирдлага (ээлжийн ахлах, ажил удирдагч)-аас жилд нэгээс доошгүй удаа авч шалгалт өгч тэнцсэн байна.
- 1.4. Ажил эхлэхийн өмнө заавал “Ажлын аюулын шинжилгээ”-г хийсэн байна.
- 1.5. Унах эрсдэлтэй тохиолдолд зохих хяналтын арга хэмжээг заавал авч хэрэгжүүлнэ.
- 1.6. 1.3 метрээс илүү өндрөөс унах эрсдэлтэй тохиолдолд уналтаас сэргийлэх эсвэл уналтыг зогсоох хэрэгслийг заавал ашиглана.
- 1.7. Өндөрт ажиллах үед ажлын тавцангаас биеийн аль ч хэсгийг илүү гаргаж ажиллахыг хориглоно.

ХОЁР. УНАЛТААС СЭРГИЙЛЭХ

- 2.1. Хөдөлгөөнгүй болон түр ажлын тавцан ашиглах
 - ❖ Боломжтой бол ажлын тавцан суурилуулах, эсвэл барилгын шат босгох зэргээр аюулгүй ажлын талбайг бий болгоно.
 - ❖ Ажлын тавцан болон барилгын шат нь бүтэн шалтай, хажуугийн хашлагатай, шал нь хамгаалалтын хаяавчтай байх ёстой бөгөөд аюулгүй авирах, буух нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 2.2. Унахаас хамгаалах ба уналт зогсоох
 - ❖ Уналтаас хамгаалах хэрэгслийг:
 - a. Зөвхөн ажлын тавцан болон биет хаалт хашилт ашиглах боломжгүй үед ашиглана.
 - b. Хүн унах эрсдэлтэй байрлалд хүрэхээс урьдчилан сэргийлнэ.
 - c. Бэхэлгээний цэг эсвэл бэхэлгээний шугамд өндрийн бүсийг татлагаар холбосон байна.
 - ❖ Уналт зогсоох хэрэгслийг зөвхөн уналтаас хамгаалах хэрэгсэл ашиглах боломжгүй бөгөөд тухай хүн:
 - ❖ Унах эрсдэлтэй байрлалд хүрэх боломжтой;

Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02
	Хувилбар: 1

- a. Уртыг нь тааруулах боломжтой татлага хэрэглэсэн бөгөөд хамгаалалтгүй зах ирмэгт хүрэх боломжтой;
- b. Биеийн жинг нь даахааргүй гадаргуу дээр ажиллаж байгаа үед хэрэглэнэ.
- c. Уналтыг зогсоох систем нь дараах зүйлсээс бүрдэнэ:
 - ❖ Зөвшөөрөгдсөн бүтэн биеийн бүс;
- a. Доргилт шингээгчтэй татлага (4 метрээс илүү өндрөөс унах эрсдэлтэй бол);
- b. Уналтыг хязгаарлах богино татлага (4 метрээс бага өндрөөс унах эрсдэлтэй бол);
- c. Хоёр эсвэл гурван үйлдлээр онгойх түгжээ бүхий дэгээ (эсвэл карбин хэлбэрийн цагираг);
- d. Бат бэх суурьтай бэхэлгээний цэг эсвэл бэхэлгээний шугам;
 - ❖ Унахаас хамгаалах болон уналтыг зогсоох хэрэгсэлийг дараах нөхцөлийг хангаж буй эсэхийг шалгаж баталгаажуулсан байна:
- a. Туршиж шалгасан, ашиглах зөвшөөрөл олгосон;
- b. Ашиглахаас өмнө түүнийг хэрэглэх хүн үзлэг хийж шалгасан;
- c. Уналт тохиолдсоны дараа эсвэл үзлэг шалгалтаар хэт элэгдсэн эсвэл механикийн эвдрэл гарсан нь илэрвэл устгалд оруулсан;

2.3. Хөдөлгөөнт ажлын тавцан ашиглах.

- ❖ Хөдөлгөөнт ажлын тавцан ашиглахдаа:
 - a. Хөдөлгөөнт ажлын тавцанг мэргэжлийн, эрх бүхий ажилтан ажиллуулна;
 - b. Хөдөлгөөнт ажлын тавцан дээр ажиллаж буй хүн заавал сагсан дото байна;
 - c. Хөдөлгөөнт ажлын тавцан дээр ажиллаж буй бүх хүн зөвшөөрөгдсөн бэхэлгээний цэгт заавал бэхлэгдсэн байна;
 - ❖ Хөдөлгөөнт ажлын тавцанг ашиглахын өмнө түүнийг ашиглах зөвшөөрөл эрх бүхий байгууллагаас авсан байна.
 - ❖ Хөдөлгөөнт ажлын тавцан нь техникийн үзүүлэлт болон үйлдвэрлэгчийн шаардлагын төвшинд ажиллаж байгаа болохыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан байна.
 - ❖ Операторууд хөдөлгөөнт ажлын тавцан ашиглах бол тухайн ээлжийн ажлыг эхлүүлэхийн өмнө ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны шалгалтыг заавал хийх бөгөөд үзлэгийн хуудсыг хөдөлгөөнт ажлын тавцанд хадгалж, бэлэн байлгана. Ингэхдээ:
 - a. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шалгалт нь тухайн ажлын тавцанг ашиглах боломжгүй хэмжээнд хүргэх эвдрэл, доголдол гарсан эсэхийг илрүүлэхэд чиглэсэн эрсдэлийн үнэлгээнд суурилсан байна.

Өндөрт ажиллах үеийн ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-02
	Хувилбар: 1

b. Аюулгүйн тоноглол нь ажиллагаагүй буюу доголдолтой болсон бол хөдөлгөөнт ажлын тавцанг ашиглахыг хориглоно.

2.4. Бэхэлгээний цэг

❖ Байнгын бэхэлгээний цэг нь:

a. Шаардлагатай ачааллыг даах хүчин чадалтай байх;

b. Тогтмол үзлэг шалгалт хийгдсэн байх;

❖ Түр бэхэлгээний цэгийг шаардлагатай ачааллыг даах эсэхийг тогтоохын тулд ашиглахын өмнө тухай тохиолдол бүрд үнэлгээ хийнэ.

2.5. Хаалт, хашилт

❖ Онгорхой нүх рүү болон ирмэгийн давж унах эрсдэлд үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх зорилгоор хаалт, хашилтыг заавал ашиглана.

2.6. Зөөврийн шат

❖ Зөөврийн шат ашиглан гүйцэтгэх ажлыг аль болох багасгана. Зайлшгүй тохиолдолд ашиглана.

❖ Гар, хөл хоёроо зэрэг ашиглаж болохоор бол зөөврийн шатаар уналтаас хамгаалах хэрэгсэл зүүгээгүй хүн өгсөж эсвэл бууж болно. Ингэхдээ шат руу харсан байрлалаар, гишгүүр алгасалгүйгээр гурван цэгийн дүрэм баримтлан авчирч, бууна.

❖ Зөөврийн шатыг аюулгүй хадгалж, ашиглахын өмнө шалгаж, засвар үйлчилгээ хийсэн байна.

ГУРАВ. ДЭЭРЭЭС ЭД ЗҮЙЛ УНАХ

3.1. Өндөрт ажил гүйцэтгэж байгаа бол:

❖ Эд зүйл унах бүсэд хүн орохоос сэргийлж ажлын талбайг тойруулан хаалт, хашилт хийж тусгаарласан байна.

❖ Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж унахаас сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.